



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар Б/11

Цэнхэрмандал сум

Албан хаагчдад хоолны зардлын нөхөх
төлбөр олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Боловсролын сайдын 2024 оны 10 срын 14-ний өдрийн 1/1536 дугаар албан бичиг, 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 1/554 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын газрын даргын 2024 оны 10 сарын 25-ны өдрийн 402 дугаар албан бичгийн дагуу тус Хүүхдийн цэцэрлэгийн албан хаагчдад нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг олгосугай.

2. Нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 5000 (таван мянга)-н төгрөгөөр тооцон тухайн сарын ажлын өдрөөр бодож цалингийн санд багтаан олгохыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА